

“ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ”
АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2025 оны жилийн эцсийн байдлаар/

2025.12.15

Орхон аймаг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2025 онд Хүрэх түвшин	Төсөв		Хүрсэн түвшин (биелэлт)	Хэрэгжилтийн хувь
				Зарцуулсан төсөв	Эх үүсвэр хаанаас		
ЗОРИЛТ 1. ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ							
1.1	Эрүүл аюулгүй сургуулийн чиглэлээр мөрдөгдөж буй хууль эрх зүйг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйгээр хангах	Хууль эрх зүйн хэрэгжилт сайжирсан байна.	Хэрэгжилтийн хувь 80	-	-	- Тайлант хугацаанд Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам, хүүхэд хамгааллын тухай хууль болон эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал, эрх зүйн баримт бичгүүдийн талаар 2 удаагийн чиглэл, мэдээлэл сургалтыг зохион байгуулж, тус сургалтад 95 сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулан арга зүйгээр хангаж ажилласан. - Эрүүл ахуйн тухай, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд, Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6799:2019, Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6782:2019 стандарт, дүрэм, журмыг сурталчлах, таниулах зорилгоор Эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан ЕБС болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч нарыг чадавхжуулах сургалтын удирдамж, хяналт шалгалтын нийтлэг журмын хүрээнд нийт 72 удирдлага, албан тушаалтан, ажиллагсдад “Сургууль, цэцэрлэгийн эрүүл, ахуй, дотоод хяналтыг сайжруулах нь” сэдвээр сургалтыг зохион байгуулж чадавхжуулсан. - 10.6.2 кодтой “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-д Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэмд орсон өөрчлөлтийн дагуу хяналтын хуудаст өөрчлөлт оруулах 1 саналыг салбарын хяналтын газарт хүргүүлсэн байна.	80
1.2	Эрүүл аюулгүй, сургуулийн ээлтэй орчныг бий болгох	Хүүхдийн байгууллагад эрүүл ахуйн үнэлгээ хяналт шалгалтын тоо	Хяналт шалгалт хийгдсэн байна.	-	-	Тайлант хугацаанд Орхон аймагт нийт 24 ерөнхий боловсролын сургууль, 39 сургуулийн өмнөх боловсрол, 1 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу нийт 64 боловсролын байгууллагад 36336 хүүхэд суралцаж байна. Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 44 боловсролын байгууллагыг хамруулсан. Хяналт шалгалтаар нийт 340 зөрчлийг илрүүлж, 173 зөрчилд улсын байцаагчийн 23 албан шаардлагыг хүргүүлж, 100 зөрчлийг газар дээр нь арилгуулж, нийт зөрчлийн 80%-ийг арилгуулж ажилласан байна.	70

1.3	Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэдээллийн урсгал, мэдээлэл солилцоог сайжруулан хариу арга хэмжээг салбар дундын байгууллагуудтай шуурхай авч хэрэгжүүлэх	Салбар дундын уялдаа холбоо	Салбар дундын уялдаа холбоо сайжирсан байна.	3	4	Баян-Өндөр сумын хүүхэд хамгааллын хамтарсан баг 4 удаа хуралдаж, эцэг эх нь архины хамааралтай, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 6 тохиолдлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүний эрхийн тухай ярилцъя хурал, уулзалтад хамтран оролцож, хүүхдийн тэргүүлэх өвчлөл, хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн.Орхон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлөөс 2025 оны 6 дугаар сард сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын амралт эхэлсэнтэй холбоотойгоор 2-6 насны хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчид ажлын байдлаас шалтгаалан гэртээ харгалзах хүнгүй үлдээх, осол гэмтэлд өртөх эрсдэлтэй тул 0-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх саран хамгаалагчдын ажлын цагт уян хатан зохицуулалт хийх тухай Засаг даргын чиглэлийг байгууллагуудад хүрүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.Өсвөр үеийн кабинетад насанд хүрээгүй өсвөр насны 3 жирэмсний тохиолдлын мэдээллийг шуурхай солилцож хурлаар хэлэлцүүлэн харьяаллын өрхийн эмч болон БОЭТ-н төрөх тасаг БЗДХ-н кабинет, сэтгэлзүйч, хүүхэд хамгааллын багтай хамтран тусламж үйлчилгээ үзүүлсэн.“Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” сургалт хэлэлцүүлгийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж салбар дундын уялдаа холбоог сайжруулан ажилласан. Тус хэлэлцүүлэгт ЕБС-ийн ахлах ангийн 120 сурагч хамрагдаж тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгож хамтран ажилласан.	100
ЗОРИЛТ 2. СУРАЛЦАГЧ, БАГШ АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ							
2.1	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагаан д хамрагдсан хүүхдийн тоо	300	-	-	Тайлант хугацаанд өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 3 албан тоот, 3 мэдээлэл, 2 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгсөн. - ЭМС-ын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дугаар тушаалаар батлагдсан өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журмыг 7 СӨЭМТ-ийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан. -ЭМГ-аас хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 354 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, дунд ангийн 70 багшийг хамруулж чадавхжуулсан. -Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд ЭМ-ийн олон талт боловсрол олгох сургалтыг	100

					1-12 дугаар ангийн 150 хүүхдэд зохион байгуулж, хүүхдийн аюулгүй тусламжийг дэмжих, аюулгүй байдлыг хангах постер мэдээлэл зөвлөмжийг 17 сургуулийн 586 сурган хүмүүжүүлэгч, 2909 сурагч, эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн. -Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ,ХГБХГ,ЦГ-тай хамтран “Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсьё” аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан. -Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгуулж, 552 охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 33 хүүхдийг эмчийн хяналтад авсан. -“Өсвөр насны охид хөвгүүдийн нөхөн үржихүйн онцлог, эрүүл ахуй, хорт зуршил ба эрүүл мэнд сэдвүүдийн хүрээнд СӨЭМТ-ийн харьяа ЕБ-ын 13 сургуулийн 7-12 дугаар ангийн 3369 хүүхдэд 19 удаагийн сургалтаар НҮЭМБ олгож, 2322 гарын авлага түгээж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. - Тамхины хор нөлөөний талаар 35 удаагийн сургалтад 20 сургууль болон Орхон МСҮТ-ийн оюутан, сурагчид, иргэд 10100 хүн хамрагдаж, 16 төрлийн 2408 тараах материал тараасан. ЭМГ-ын цахим хуудсаар хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 41 постер, 10 видео шторк нийт 51 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 126762 иргэнд түгээсэн.	
2.2	Сургуульд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч, багш нарыг чадавхжуулах	Сургалтад хамрагдсан багш, ажилтны тоо	80		- Тайлант хугацаанд Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, нийгмийн ажилтныг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн тушаал, сургууль цэцэрлэгт мөрдөгдөх эрүүл ахуйн дүрэм, журам, дотоод хяналтыг сайжруулах, хүүдийн өвчлөлийн байдал, анхан шатны тусламж үзүүлэх арга зүй, өсвөр үеийн эрүүл мэндийн анхаарах асуудлуудын талаар давхардсан тоогоор 87 эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулсан. - Боловсролын газартай хамтран "Сайн туршлага" түгээн дэлгэрүүлэх сургалтын хүрээнд “Өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох” сургалтыг зохион байгуулж анги удирдсан 70 багшийг хамруулж, өсвөр үеийнхний эрүүл мэнд, анхаарах асуудлууд болон нөхөн үржихүй, бэлгийн боловсролын талаар мэдлэг	70

						олгож тэдний эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.	
ЗОРИЛТ 3. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАНДАЛТ ЦАХИМ БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ							
3.1	Суралцагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулж, мэдээллийн системд бүртгэх	Цахим систем ашиглан бүртгэл хийсэн сургуулийн хувь	60%	-	-	Aimag.Eruulhuuhed.mn цахим системд 19 эрүүл мэндийн байгууллага, 22 ерөнхий боловсролын сургуульд цахим хаягын эрхийг нээн, сургуульд суурилсан эрт илрүүлгийн нүд, шүд, зүрхний үзлэгийг тус программд бүртгэн оруулсан. Цахим систем ашиглалт 95.4 хувь байна. Цахим ашиглалт, бүртгэл мэдээллийн чиглэлээр сургалт зохион байгуулж, дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч арга зүйгээр хангаж ажилласан.	90
		Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэг оношилгоон д хамрагдсан хүүхдийн нас, хувь	80%	-	-	Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/32 тушаалаар “Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэг зохион байгуулах” тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 2 удаа хуралдан 11 үйл ажиллагааны удирдамж батлуулан ажилласан.Үйл ажиллагааны хэрэгжилт 90,9 хувьтай байна. Сургуульд суурилсан илрүүлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн.	100
		Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоон д хамрагдсан багш нарын хувь	80%	-	-	Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 192 байгууллагын 15319 ажилтан албан хаагчдыг лавлагаа шатлалын эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хамтран ажилласан.Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн эрт илрүүлэгт 136861 хүн хамруулахаар төлөвлөснөөс 115748 хүн хамрагдаж, хамрагдалтын хувь 84,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,7%-иар буурсан. 2025 оны хичээлийн жилд ЭМС-ын 2014 оны 145 дугаар тушаалын дагуу нийт 63 боловсролын байгууллагаас хамрагдвал зохих 1331 ажилчидтай үүнээс нян тээгч илрүүлэх шинжилгээнд 1331 ажилчид буюу 100 хувь хуваарийн дагуу бүрэн хамрагдсан.	80
3.2	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд тандалт, үнэлгээ хийж, хяналт тавих	Тандалт, үнэлгээг зохион байгуулах	Тандалт, үнэлгээг зохион байгуулсан байна.	-	-	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамны салбарын улсын ерөнхий байцаагч, Боловсрол, шинжлэх ухааны яамны салбарын улсын ерөнхий байцаагчдын баталсан 03-00/02 дугаартай “Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд Ерөнхий боловсролын 10 сургуульд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Үүнээс 5 сургууль нь стандартын шаардлага хангасан бөгөөд 5 сургуулийн барилга байгууламж нь зориулалтын бус шалтгаантайгаар шаардлага хангахгүй байна. Улсын байцаагчийн стандартын шаардлага хэрэгжүүлэх тухай 5 дүгнэлт гаргаж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж	100

						байна.	
3.3	Сургуулийн гадаад дотоод орчны хөрс, аагаа, гэрэлтүүлэг ус ариун цэврийн байгууламжид эрүүл ахуйн тандалт хийх	Эрүүл ахуйн тандалт хийсэн сургуулийн хувь	20%	-	-	Байгаль орчин аялал жуулчлал залуучуудын газартай хамтран Олон улсын "Эко сургууль, цэцэрлэг"-хөтөлбөрт 4 цэцэрлэг I-II шатны сургалтад амжилттай хамрагдаж батламж авсан. "Хоггүй орчин-Хотын соёл" аяны хүрээнд хог ангилах хогийн савыг гадаа талбайд 15 хүүхдийн байгууллага байршуулан хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн савтай болж хүүхдийн эрүүл аюулгүй ээлтэй орчныг бүрдүүлсэн байна. Үүдний хүлээн авах хэсэг, гадаа талбай, гадаа хог ангилах цэгээр дамжуулан хүүхэд, багш, ажилтан хогоо ангилж, ялгах дадалд суралцаж хэвшсэн. Хүүхдийн боловсролын байгууллагын 22.7 хувь нь гадаад орчин, хөрсний бохирдол, хог хаягдлын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаж байна. Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны салбарын улсын ерөнхий байцаагчдын баталсан 03-00/02 дугаартай "Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай", 03-00/03 дугаартай "Бүх шатны боловсролын сургалтын багууллагын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл үйл ажиллагааг шалгах" удирдамжуудын хүрээнд ерөнхий боловсролын сургууль болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн ус болон хөрсний шинжилгээг Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораториоос хариуг татан авч үзэхэд нийт 23 дээжний хөрсний шинжилгээ 100 хувь шаардлага хангасан бол 7 сургуулийн буюу 30,4 хувь нь ундны усны шаардлага хангаагүй байсан. Иймд ундны усны шинжилгээний хариу эерэг гарсан сургуулиудад халдваргүйжүүлэлт хийн давтан шинжилгээг авахад эрүүл ахуйн шаардлага хангасан үзүүлэлттэй гарч хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн.	100
3.4	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоогоор эрсдэлт хүчин зүйл илэрсэн суралцагчдыг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох	Хүүхэд, өсвөр үеийнхэнд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.	-	-	-	- Тамхины хор нөлөөний талаар 35 удаагийн сургалтад 20 сургууль болон Орхон МСҮТ-ийн оюутан, сурагчид, иргэд 10100 хүн хамрагдаж, 16 төрлийн 2408 тараах материал тараасан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран ШШГТ-ын хяналтад байдаг 21 хүүхдэд Эрүүл бус хүнсний хэрэглээ, Өсвөр насныханд зонхилон тохиолдох хоол боловсруулах замын эмгэг, хорт зуршил сэдвийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. "Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё" аян зохион байгуулагдаж нээлтийн арга хэмжээний сургалт хэлэлцүүлэгт Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 120 сурагчид хамрагдаж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгосон. Тус аяны хүрээнд 4 сургуулийн 296 сурагчдад сэтгэл зүйн сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажилласан.	100

					2 сумын 28 багийн нутаг дэвсгэрт Тамхи болон тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулдаг 57 дэлгүүрт хяналт хийж, зөвлөмж, уриалга хүргүүлсэн ба Жаргалант сумын ЕБС-ийн дунд, ахлах ангийн хүүхдүүдийн дунд электрон тамхины хэрэглээнд 7 удаа хяналт хийж, илрүүлэх, арилгах ажлыг зохион байгуулсан. Аймгийн хууль, эрх зүйн хэлтсийн “Хуулийн цаг” нэвтрүүлэгт Электрон тамхины хор хөнөөлийн чиглэлээр 2 эмч оролцож иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгосон. ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдад “Электрон болон бусад төрлийн тамхины хэрэглээ, биед үзүүлэх сөрөг нөлөөний талаар 8 удаагийн сургалтыг зохион байгуулж 529 сурагч эцэг эхийг хамруулан 142 гарын авлагыг түгээж мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. - Эрүүл мэндийн салбарын 10 пэйж хуудсаар өдөр бүр мэдээлэл оруулж иргэдэд түгээн ажилласан ба нийт давхардсан тоогоор 486 мэдээлэл оруулж, хандалтын тоо 107262 байна.	
	Суралцагчдын амны хөндий шүд цоорлын эрүүлжүүлэлтийн хувь		-	-	Сургуульд суурилсан илрүүлэг- 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн.Үүнд - ЭМГ, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлэг үзлэгт 2276 хүүхэд хамрагдахаас 95,1% нь хамрагдсан.Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 2018 /88,6%/, шүдний гажигтай 681 /27,7%/, шүдээ бүрэн угаадаггүй 1998 /81.5%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 1783 хүүхэд байна.	90
	Суралцагчдын өвчлөлийн түвшин	-	400,0 сая	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	- Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/32 тушаалаар “Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэг зохион байгуулах” тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 2 удаа хуралдан 11 үйл ажиллагааны удирдамж батлуулан ажилласан. Үйл ажиллагааны хэрэгжилт 90,9 хувьтай байна. - Сургуульд суурилсан илрүүлэг- 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн. - Цагаан тоосны дэгдэлтийн бүс болох Жаргалант сум, Баянцагаан, Говил багийн иргэд болон хүүхдийн байгууллагуудад эрүүл мэндийг дэмжих 6 төрлийн өртөөт өдөрлөгийг 9 удаа зохион байгуулж, нийт 1510 иргэнийг хамруулсан. - Тайлант хугацаанд БОЭТ-ийн хүүхдийн тасагт 2214 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын замын эмгэг 1873 (84.5%), хоол боловсруулах замын эмгэг 200 (9.0 %), арьс, харшлийн	90

						шалтгаант эмгэг 51 (2.3%), мэдрэл 47 (2.1%), зүрх судасны эмгэг 15 (0.7%), бусад 15 (0.7%) эзэлж байна.	
ЗОРИЛТ4. СУРГУУЛЬД АЮУЛГҮЙ, ЭЭЛТЭЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ							
4.1	Ус, усан хангамж ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан сургуулийн тоог нэмэгдүүлэх	Ундны цэвэр ус уух боломж бүрдүүлсэн сургуулийн хувь	40%	-	-	Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 26 ерөнхий боловсролын сургуулиуд нь “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6728:2019 стандартын шаардлагыг 100% бүрэн ханган ажилладаг, өдөрт хүүхэд бүр 1 литрээс доошгүй ундны ус уух боломжоор бүрэн хангагдсан ус цэвэршүүлэгчтэй, түүний шүүлтүүрийг тогтмол хугацаанд сольж хэвшсэн. “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл” MNS 7005:2023 стандартын хэрэгжилтийг хангаж сургууль тус бүр жилд 2 удаа ундны усыг Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторид хими, нян судлалын шинжилгээнд тогтмол хамруулж хэвшсэн. Эрүүл мэндийн яам, Боловсролын яамны салбарын улсын ерөнхий байцаагчдын баталсан 03-00/03 дугаартай “Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл үйл ажиллагааг шалгах” удирдамжийн хүрээнд хийгдсэн шалгалтаар 23 сургууль ундны усны дээжийг хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө лабораторид хүргүүлсэн. Тус дээжээс 7 буюу 30,4 хувь нь ундны усанд бактерийн бүлгийн ерөнхий тоо их үзүүлэлттэй гарсан. Тус сургуулиудад улсын байцаагчийн стандартын шаардлага хангаагүй тухай дүгнэлтийг хүргүүлж шугамын усны цоргыг халдваргүйжүүлэн давтан шинжилгээнд хамруулахад бактерийн бүлгийн ерөнхий тоо буурсан үзүүлэлттэй гарч хичээл сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлсэн.	100
		Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай сургуулийн эзлэх хувь	80%	-	-	Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6799:2019 стандартын дагуу Ерөнхий боловсролын 26 сургууль нь ариун цэврийн байгууламжийн шаардлагыг 100 хувь хангасан боловч нийт сургуулийн 72,5 хувьд хүүхдийн хүчин чадал хэтэрснээс нэг хүүхдэд ногдох суултуур болон гар угаалтуурын хүрэлцээ хангалтгүй байна.	70
		Шүд угаах орчин нөхцөлийг бүрдүүлэх, эцэг эх асран	-	-	-	- Аймгийн хүүхдийн байгууллагуудад эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах хэсэгтэй эсэхэд ЭМГ-аас нэг удаа үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн. Үнэлгээний дүнгээр СӨБ-ийн байгууллагын 95.0% нь шаардлага хангасан байна. ЕБС-иудаас шүд угаах орчин бүрдүүлэн, шүд угаах булан байгуулсан нэг сургууль, шүд угаах булангийн бэлтгэл ажлыг хийж эхэлсэн гурван сургууль, шүд угаах цагийг тогтмолжуулан хэрэгжүүлж буй дөрвөн	90

		хамгаалагчд ад амны хөндийн эрүүл мэндийн боловсролы г олгох				сургууль байна. -Шүд угаах 24/3 аяны хүрээнд 12766 хүнд сургалт зохион байгуулж ,боловсролын байгууллагын 56, сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” аянд 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багшийн оролцуулан,39 цэцэрлэг, 24 сургууль, политехникийн 1 их дээд сургууль 1 нийт 65 байгууллагын 1214 ажилчдад шүд угаах онол дадлага хосолсон сургалт зохион байгуулсан. - Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” шүд, гараа зөв угааж сурах аяныг өрнүүлж эцсийн үр дүнг эцэг эх асран хамгаалагч нар хүүхдийнхээ шүд болон гарыг хэрхэн угаах уралдаанаар дүгнэж үнэллээ. Уг арга хэмжээ улсын хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багш, зохион байгуулагчаар 10 мэргэжилтэн, уралдааны шүүгчээр Орхон аймгийн шүдний мэргэжилтний холбооны 40 мэргэжилтэн,өрхийн эрүүл мэндийн төвийн 8 мэргэжилтэн нийт 630 хүний оролцоотой зохион байгуулагдлаа. Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан байна.	
4.2	Сургуулийн хоолны газрын стандартын шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулах	Шаардлага хангасан хоолны газартай сургуулийн хувь	50%			- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын 26 сургуулийн шалгалтын дүнгээр 13 сургууль шаардлага хангасан хоолны газартай байна. Шаардлага хангаагүй 13 сургууль нь хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өрөө тасалгаагаар хангагдаагүй, шаардлага хангасан агуулахгүй, урсгал чиглэлийг зөв зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрсэн нь “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл” MNS 7005:2023 стандартын шаардлагыг хангахгүй байна. - Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл, ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар хийсэн хяналт шалгалтаар нийт 108 зөрчлийг илрүүлж, 33 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 27 зөрчилд улсын байцаагчийн 5 албан шаардлагыг хүргүүлж ажилласан. Албан шаардлагын биелэлт 74,4 хувьтай хэрэгжсэн байна. Шалгалтын танилцуулгыг Эрүүл мэндийн яам, Орхон аймгийн Боловсролын газарт тус тус хүргүүлэн ажилласан.	100

ЗОРИЛТ 5. СУРГУУЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

5.1	Ерөнхий боловсролын бүх сургуулийг эмчтэй болгоно	Эмчтэй сургуулийн тоо	23 сургууль			Ерөнхий боловсролын 24 сургуульд 20 эмч орон тоогоор ажиллаж байна. Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх байгууллагын 105 эмчийг хамруулж чадавхжуулсан. -Боловсролын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулийн 845 бүлгийн багшид сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн хичээлээр дамжуулан 18457 суралцагчид эрүүл мэндийн боловсрол олгож ажиллалаа. -Сургуулийн өмнөх боловсролын 32 цэцэрлэгийн арга зүйч болон эмчид хүүхдийн эрүүл мэнд, эрүүл ахуй агуулгын хүрээнд 5 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 64 хүнийг хамруулсан.	80
5.2	Сэтгэл зүйчийн тоог нэмэгдүүлж, сэтгэлзүйн сургалтад хамруулж чадавхжуулна	Сэтгэл зүйчтэй сургуулийн хувь	55%			Ерөнхий боловсролын 24 сургуулийн 20 эмч, 29 нийгмийн ажилтан, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 2 сэтгэл зүйч, Ерөнхий боловсролын сургуулийн 20 сэтгэл зүйч сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. - “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 51 төлөөллийг хамруулан зохион байгуулсан. 15, 17, 24-р сургуулийн багш, ажилчид сэтгэлзүйчдэд "Сэтгэцийн эрүүл мэнд", "Тоглоомын хамаарал" сургалтыг зохион байгуулж 143 хүнийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн 83,3 хувьд сэтгэл зүйч ажиллаж сэтгэлзүйн зөвлөгөө өгч байна.	100
5.3	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг товлот дархлаажуулалт хамруулах ажлыг зохион байгуулах	Зорилтот насны суралцагчдын хүний папилома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдалтын хувь	50%	13,5 сая 18,8 сая	ОНТ НҮБ ХС	Хүний папиллома вирусийн эсрэг вакцины хамралтыг нэмэгдүүлэх аяныг сум, өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулийн дунд зохион байгуулагдаж байна. Хүний папиллома вирусийн эсрэг вакцины хамралт 30% байна.. Дэлхийн дархлаажуулалтын 10 хоногоор “Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрд хүртээе” өдөрлөгийг Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн төв 9, ерөнхий боловсролын сургууль 23 хамтран 4500 гуруй сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл хамрагдсан. Мөн нөлөөллийн уулзалтад орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн салбарын төлөөлөл 100, сургагч багш бэлтгэх сургалтад сурагчид болон эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллөөс 200 багш бэлтгэн сургууль бүр арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласан. Засаг даргын 2025 оны А/819 дүгээр захирамжаар ажлын хэсэг,	70

						төлөвлөгөө, үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 8,5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Ажлын хэсэг 1 удаа хуралдаж салбаруудад үүрэг чиглэл өгсөн. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу ерөнхий боловсролын сургуулиудад үүрэг даалгавар албан тоотоор хүргүүлсэн. ЭМГ-ын даргын А/86 дугаар тушаалаар эцэг, эх, асран хамгаалагч нарт вакцины үр, дүн ач холбогдлыг таниулах ухаалга, нөлөөллийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. Манай аймагт товллын дагуу 2013 онд төрсөн 2417 хүүхдээс 1221(43.6%), 2014 онд төрсөн 2341 хүүхдээс 1114(60.4%), нийт хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдаж, хамралт 55,2% байна. Дархлаажуулалтын хамралт 24,4% нэмэгдсэн байна.	
		Зорилтот насны суралцагчдын сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын 1-р тунгийн хамрагдалтын хувь	81%	-	-	Сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын 1-р тунд 2547 хүүхэд хамрагдахаас 2395 хамрагдсан байна. Хамрагдалтын хувь 94.0%	100
		Зорилтот насны суралцагчдын сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын 2-р тунгийн хамрагдалтын хувь	72%	-	-	Сахуу татрангийн эсрэг дархлаажуулалтын 2-р тунд 1986 хүүхэд хамрагдахаас 1782 хүүхэд хамрагдсан байна. Хамрагдалтын хувь 89.7%	100
5.4	Сургуулийн орчинд халдварт өвчин, хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн	Сургуулийн орчинд халдварт өвчин, хоолны хордлого бүртгэгдсэн	0	-	-	Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 51.5% амьсгалын зам, 23.7% БЗДХ, 4.7% гэдэсний, 20.2% бусад халдварт өвчин байна. 4 төрлийн 225 хам шинж, сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор их байна. Цэврүүт тууралт 71,8%, халууралт тууралт 16,2%, бусад хам шинж 12% тус тус байна.	90

	боловсрол олгох, хариу арга хэмжээ авч ажиллах	тохиолдлын тоо				-Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 4, Засаг даргын 2 албан даалгаврын хэрэгжилтийг хангахад АЗДТГ,БГ,ХГБХГ,ОБГ-тай хамтран ажилласан. Үүнд: ЭМС-ийн Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, ялган оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай 01 дугаар албан даалгаврын биелэлт 93,5%, Улаанбурхан өвчнөөс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах, дархлаажуулалтыг зохион байгуулах тухай 08 дугаар албан даалгаврын биелэлт 90,8%, Амьсгалын замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн засаг даргын 01 дугаар албан даалгаврын биелэлт 91,3% тус тус байна. -Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг 8 хийж, 17 асуудал хэлэлцэж, 14 шийдвэр гарган,хэрэгжилтийг 95,6%-тай ханган ажилласан. -Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг аймгийн засгийн даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулж, салбар дундын уялдаа холбоог хангаж, Аймгийн Онцгой Комисст танилцуулан, шийдвэрлүүлж хариу арга хэмжээг чадавхжуулж ажилласнаар 2025 оны 9 сараас хойш улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, бэлэн байдал, хариу арга хэмжээ,тушаал шийдвэрийн хэрэгжилтийн чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаа, Хүүхдийн байгууллагуудад 1 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан.Зөвлөмжийн хэрэгжилт 92,9% байна.	
5.5	Багш, ажилтнууд, суралцагчдын урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог зохион байгуулах	Багш, ажилтнууд, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хувь	85%	-	-	2025 оны хичээлийн жилд ЭМС-ын 2014 оны 145 дугаар тушаалын дагуу нийт 63 боловсролын байгууллагаас хамрагдвал зохих 1331 ажилчидтай үүнээс нян тээгч илрүүлэх шинжилгээнд 1331 ажилчид буюу 100 хувь хуваарийн дагуу бүрэн хамрагдсан. Шинжилгээнд хамрагдсан ажилчдаас 78 буюу 5,8%-д MRSA эерэг илэрсэн. Нэг дэх давтан шинжилгээнд 57 ажилтан хамрагдаж 1 эерэг гарсан, 2 дахь давтан шинжилгээнд 29 ажилтан хамрагдаж 1 эерэг гарсан, 3 дахь давтан шинжилгээнд 16 ажилтан хамрагдаж эмчлэн эрүүлжсэн. Хяналтад 56 ажилтан байснаас тушаалын дагуу эмчлэн эрүүлжих хугацаанд эрүүлжиж, давтан шинжилгээнд хамрагдаж 100 хувь эрүүл ажиллагсдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд хамруулсан.	100
		Насанд тохирсон эрт илрүүлгийн үзлэгт	85%	-	-	-Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/32 тоот тушаалын дагуу сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэг зохион байгуулах ажлын хэсэг 2 удаа хуралдан 11 үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилт 86,3 хувьтай байна. Сургуульд суурилсан илрүүлэг- 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557	100

		хамрагдсан суралцагчдын хувь				(99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн. Үүнд: Шүдний илрүүлэгт 2276 хүүхэд хамрагдахаас 95,1% нь хамрагдсан. Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 2018 /88,6%/, шүдний гажигтай 681 /27,7%/, шүдээ бүрэн угаадаггүй 1998 /81.5%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 1783 хүүхэд байна. Нүдний илрүүлэгт 2576 хүүхэд хамрагдахаас 94,6% нь хамрагдсан. Илрүүлгээр нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай 427 буюу 17.5% нь байна. Холын хараа тэнцээгүй 292 /11.9%/, ойрын хараа тэмцээгүй 100 /4.1%/, стерео хараа тэнцээгүй 244 /10%/ байна. Зүрхний эмгэг илрүүлэг үзлэгт 2576 хүүхэд хамрагдахаас 92.9%-ыг хамруулж, үүнээс зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй илэрсэн 363/15,1%/ хүүхдээс 315 буюу 86,7%-ийг зүрхний эхо оношилгоонд хамруулан 27 хүүхдэд зүрхний эмгэг илэрч, хяналтад авсан байна.	
5.7	Хүүхэд өсвөр үеийн, нөхөн үржихүйн чиглэлийн мэдээллийг олон нийт, иргэдэд түгээж, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах	Цахим зөвлөмж, видео, шторкийг олон нийт иргэдэд түгээсэн байна.	-	-	-	- ЭМГ-ын цахим хуудсаар хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 41 постер, 10 видео шторк нийт 51 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 126762 иргэнд түгээсэн. - Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс сэргийлэх, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, эх, нярайн эрүүл мэндийн чиглэлээр 27 постер, 8 видео шторк, нийт 35 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 44072 эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн байна. -Хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд, дархлаажуулалтын чиглэлээр 57 зурган постер, 36 видео шторк, 3 рийл, нийт 96 мэдээллийг цахим хуудсанд байршуулж давхардсан тоогоор 2214544 иргэд, эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн байна.	85
Зорилт 6. Салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах							
6.1	Хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулах, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах	Сургалтын тоо	-	-	-	Баян-Өндөр сум нь хамтарсан 26 багтай бөгөөд нийт салбар дундын 224 гишүүнтэй. Хамтарсан багийн гишүүдийн 28 буюу 12.5 хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нар хамтран ажиллаж, эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн, салбар дундын уялдаа холбоог хангаж байна. Анхан шатны тусламж үйлчилгээнд өсвөр үеийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, далд хүчирхийллийг илрүүлэх, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажлын байранд чадавхжуулах 1 удаагийн сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн 7 төвийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, хамтарсан багаар ажиллах, мэдээллийг урсгалын дагуу шуурхай түгээх, эрсдэлт нөхцөлд	80

[illegible]

“ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Орхон аймаг

2025.12.15

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин 2025 он	Хүрсэн түвшин / 2025/	Тайлбар
			Он	Түвшин			
1.	Багш, ажилчдын эрүүл мэндийн	Хувь	-	-	75	100	2025 оны хичээлийн жилд ЭМС-ын 2014 оны 145

	үзлэгт хамрагдалт						дугаар тушаалын дагуу нийт 63 боловсролын байгууллагаас хамрагдвал зохих 1331 ажилчидтай үүнээс нян тээгч илрүүлэх шинжилгээнд 1331 ажилчид буюу 100 хувь хуваарийн дагуу бүрэн хамрагдсан.
2.	Суралцагчдын амны хөндий шүд цоорлын эрүүлжилт	Хувь	2023	32.6	45.0	88.3	Шүдний илрүүлэгт 2276 хүүхэд хамрагдахаас 95,1% нь хамрагдсан. Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 2018 /88,6%/, шүдний гажигтай 681 /27,7%/, шүдээ бүрэн угаадаггүй 1998 /81.5%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 1783 хүүхэд байна.
3.	Халдварт өвчин, хоолны хордлогын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөтэй сургууль	хувь	2023	5.0	50	8.3	Тайлант хугацаанд халдварт өвчин, хоолны хордлогын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөтэй сургууль 8.3 хувийг эзэлж байна.
4.	Халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн сургуулийн тоо, өвчний төрлөөр	Тоо	-	-	0.0	18	2025 онд 18 сургуульд халдварт өвчний 74 тохиолдол бүртгэгдсэн байна.
5.	Сургуулийн орчинд хоолны хордлогын дэгдэлт бүртгэгдсэн сургуулийн тоо	Тоо	-	-	0.0	0.0	Сургуулийн орчинд хоолны хордлогын дэгдэлт бүртгэгдээгүй байна.
6.	Сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсэн сургуулийн тоо (2 болон түүнээс дээш)	Тоо	2024	30	30	0.0	Сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсэн сургууль байхгүй байна.
7.	Сургуулийн орчинд бүртгэгдсэн осол гэмтлийн тохиолдлын тоо	Тоо	2023	10123	9500	25	2025 онд сургууль, цэцэрлэгийн орчинд осол, гэмтлийн 25 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор нэмэгдсэн байна.